



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/308

Номгон

Хүнс, хөдөө аж ахуйн газарт газар эзэмшүүлэх  
тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянхонгор сумын Есөнбулаг 9 дүгээр баг, Шинэ суурьшлын бүс, Тээвэрчдийн гудамж-5, 505б тоот хаягт байрлах Хүлэмж, дарлагийн зориулалттай 11269 м<sup>2</sup> /1.1га/ газрыг, тээвэрчдийн гудамж-5, 505а тоот хаягт байрлах зоорийн зориулалттай 8664 м<sup>2</sup> /0.8га/ газрыг тус тус аймгийн "Хүнс, хөдөө аж ахуйн газар"-т /9007628/ эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

631010785